



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/97/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.	16
5.2 Албан шаардлага	16
Захирлын 2022 оны 12 дугаар сарын 07-ны Б/34 тоот тушаалаар комисс томилогдон тооллогыг 08-18-ны өдөр хийсэн ч тооллогыг үнэн зөв хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 72, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийг зөрчсөн, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.	16
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.20 № 77

танай _____ ны № _____ т

**БУЛГАН СУМЫН ЗУРГААДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.БАЯРМАА ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 1 хөтөлбөр 8 зориулалт арга хэмжээний хүрээнд 488,247.7 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 479,059.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтын үр дүнд үр дүнгийн урамшуулал авах болзол хангасан 4 багш, сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр IV түвшинд үнэлэгдэн Боловсролын ерөнхий газраас ирүүлсэн чиглэл шийдвэрийн дагуу үр дүнгийн болон нэмэлт урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг.

байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,169,881.26	55,102,944.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	9,187,914.75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	9,187,914.75
3121	Төгрөг	-	9,187,914.75
31211	Төрийн сангийн харилцах	-	9,187,914.75
33	АВЛАГА	5,000.00	-
335	Бусад авлага	5,000.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	52,164,881.26	45,915,029.26
351	Түүхий эд материал	235,850.00	112,100.00
35130	Эм боох материал	235,850.00	112,100.00
354	Хангамжийн материал	51,929,031.26	45,802,929.26
35410	Бичиг хэргийн материал	923,900.00	899,350.00
35420	Аж ахуйн материал	26,867,272.40	18,129,278.00
35460	Хүнсний материал	3,481,458.00	4,762,040.00
35470	Бусад хангамжийн материал	20,656,400.86	22,012,261.26
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	436,747,691.21	415,837,870.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	436,747,691.21	415,837,870.94
392	Биет хөрөнгө	394,074,774.40	373,527,454.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	387,901,207.26	387,901,207.26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,780,655.68)	(48,879,171.24)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	30,834,798.00	29,228,908.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,987,249.16)	(19,849,109.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,669,380.50	26,590,741.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,870,736.12)	(8,818,261.65)
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,098,514.40	6,307,014.40
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,726,906.80)	(1,887,296.36)
39217	Ном	2,936,422.00	2,933,422.00
393	Биет бус хөрөнгө	42,672,916.81	42,310,416.85
39301	Програм хангамж	1,600,000.00	1,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(427,083.19)	(789,583.15)
39303	Бусад биет бус хөрөнгө	41,500,000.00	41,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	488,917,572.47	470,940,814.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	4,819,815.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	4,819,815.00
413	Өглөг	-	4,819,815.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	4,819,815.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	488,918,572.47	466,121,999.95
51	Засгийн газрын хувь оролцоо	488,918,572.47	466,121,999.95
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	151,246,003.07	151,246,003.07
512	Хуримтлагдсан үр дүн	(43,971,789.94)	(66,768,362.46)
51210	Өмнөх үеийн үр дүн	(43,971,789.94)	(43,971,789.94)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(22,796,572.52)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	381,644,359.34	381,644,359.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	488,918,572.47	470,941,814.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс ны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	433,051,363.62	493,271,606.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	148,050.00	5,023,906.00
120	Нийтлэг татварын бус орлого	148,050.00	5,023,906.00
120001	Хувьцааны ногдол ашиг	24,300.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	123,750.00	5,023,906.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		4,920,406.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	123,750.00	103,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	432,903,313.62	488,247,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,142,400.00	382,243,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	382,243,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	376,142,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,510,913.62	106,004,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,510,913.62	106,004,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	434,319,017.69	516,065,178.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	434,319,017.69	516,065,178.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,872,794.87	513,218,091.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,446,834.72	302,211,411.80
210101	Үндсэн цалин	166,311,802.21	221,136,556.40
210102	Нэмэгдэл	70,281,577.35	65,985,523.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,484,999.68	-
210104	Урамшуулал	21,368,455.48	15,089,332.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,815,206.46	38,942,170.83
210201	Тэтгэврийн даатгал	25,350,792.47	26,654,690.84
210202	Тэтгэмжийн даатгал	2,590,362.76	3,126,206.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,207,087.91	2,497,545.25
210204	Ажилгүйдлийн даатгал	510,791.58	606,093.53
210205	Эрүүл мэндийн даатгал	5,156,171.74	6,057,634.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,740,913.62	88,060,415.00
210301	Гэрэл, цахилгаан	1,890,423.62	3,816,915.00
210302	Түлш, халаалт	52,039,820.00	76,042,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,810,670.00	8,200,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,552,938.00	10,755,334.00
210401	Бичиг хэрэг	1,180,820.00	-
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	487,916.00	-
210404	Ном, хэвлэл	20,960.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,485,800.00	1,540,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,036,322.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,097,700.00	-
210408	Бараа материал акталсны зардал	1,043,420.00	9,214,634.00
2105	Нормативт зардал	9,838,868.00	33,695,434.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	108,000.00	-
210502	Хоол, хүнс	9,730,868.00	33,695,434.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	-
210702	Дотоод албан томилолт	64,000.00	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,900.00	814,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	148,900.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,265,134.07	37,739,326.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	145,650.00	8,488,530.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	369,660.00	3,423,570.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,749,824.07	25,827,226.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,446,222.82	2,847,086.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	2,847,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	2,847,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,646,222.82	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,646,222.82	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	86.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	86.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,267,654.07)	(22,793,572.52)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,267,654.07)	(22,796,572.52)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	434,917,763.62	488,247,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,014,450.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	2,014,450.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,007,225.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,007,225.00	
120009	Бусад орлого	1,007,225.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	432,903,313.62	488,247,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	376,142,400.00	382,243,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	382,243,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	376,142,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	250,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	250,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,510,913.62	106,004,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,510,913.62	106,004,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	417,115,738.62	479,059,785.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,115,738.62	479,059,785.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,669,515.80	476,212,698.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	266,446,833.72	302,206,411.80
210101	Үндсэн цалин	166,311,801.21	221,136,556.40
210102	Нэмэгдэл	70,281,577.35	65,980,523.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,484,999.68	-
210104	Урамшуулал	21,368,455.48	15,089,332.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,815,207.46	38,942,170.83
210201	Тэтгэврийн даатгал	25,161,298.54	26,654,690.84

210202	Тэтгэмжийн даатгал	2,779,857.79	3,126,206.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,207,087.81	2,497,545.25
210204	Ажилгүйдлийн даатгал	510,791.58	606,093.53
210205	Эрүүл мэндийн даатгал	5,156,171.74	6,057,634.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	55,510,913.62	83,240,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,890,423.62	3,816,915.00
210302	Түлш, халаалт	51,809,820.00	76,042,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,810,670.00	3,381,085.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,018,520.00	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	499,760.00	-
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	450,700.00	-
210404	Ном, хэвлэл	33,460.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,750,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,084,600.00	-
2105	Нормативт зардал	12,433,161.00	34,976,016.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,500.00	-
210502	Хоол, хүнс	11,864,561.00	34,976,016.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	515,100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,979,984.00	1,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,979,984.00	-
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	64,000.00	-
210702	Дотоод албан томилолт	64,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	498,100.00	814,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	498,100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,902,796.00	14,033,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,532,400.00	10,253,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,370,396.00	3,780,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,446,222.82	2,847,086.62
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	2,847,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	2,847,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	30,646,222.82	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,646,222.82	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	86.62
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	86.62
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>17,802,025.00</u>	<u>9,187,914.75</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	16,794,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,794,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	16,794,800.00	-
222001	Тоног төхөөрөмж	3,780,000.00	-
223001	Бусад хөрөнгө	13,014,800.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(16,794,800.00)</u>	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,007,225.00	9,187,914.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9,187,914.75

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(43,777,535.87)		489,111,826.54
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(43,777,535.87)	-	489,111,826.54
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(194,254.07)		(194,254.07)
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(43,971,789.94)	-	488,917,572.47
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(43,971,789.94)	-	488,917,572.47
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(43,971,789.94)	-	488,917,572.47
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(22,796,572.52)		(22,796,572.52)
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	151,245,003.07	381,644,359.34	(66,768,362.46)	-	466,120,999.95

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	488,247,613.38	479,059,698.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	488,247,613.38	479,059,698.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	485,400,613.38	476,212,698.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	307,141,514.00	302,206,411.80
210101	Үндсэн цалин	241,855,348.00	221,136,556.40
210102	Нэмэгдэл	54,595,938.00	65,980,523.20
210104	Урамшуулал	10,690,228.00	15,089,332.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,680,999.38	38,942,170.83
210201	Тэтгэврийн даатгал	27,087,100.11	26,654,690.84
210202	Тэтгэмжийн даатгал	3,165,217.65	3,126,206.65
210203	ҮОМШО-ний даатгал	2,531,754.08	2,497,545.25
210204	Ажилгүйдлийн даатгал	627,429.82	606,093.53
210205	Эрүүл мэндийн даатгал	6,269,497.72	6,057,634.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,240,600.00	83,240,600.00
210301	Гэрэл, цахилгаан	3,898,000.00	3,816,915.00
210302	Түлш, халаалт	76,042,600.00	76,042,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,300,000.00	3,381,085.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,000,000.00	1,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,000,000.00
2105	Нормативт зардал	38,490,000.00	34,976,016.00
210502	Хоол, хүнс	38,490,000.00	34,976,016.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,000.00	814,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	814,000.00	814,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,033,500.00	14,033,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,253,500.00	10,253,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,780,000.00	3,780,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,847,000.00	2,847,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,847,000.00	2,847,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,847,000.00	2,847,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	488,247,613.38	488,247,700.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	382,243,500.00	382,243,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	382,243,500.00	382,243,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,004,113.38	106,004,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	106,004,113.38	106,004,200.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		9,187,914.75
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	125.00	-
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	125.00	-

631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	125.00	-
--------	------------------------------	--------	---

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00
2104	Хангамж, бараа материалын зардал	00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тайлант онд тус байгууллага “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тулгарч буй бэрхшээлийг арилгаж сурах тэгш боломж бүрдүүлэх, хувь хүний онцлогт нийцүүлэн сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг сургалтад нэвтрүүлэх” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,976.8 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	9,187.91	9,187.91
Авллага	5.00	-	(5.00)
Бараа материал	52,164.88	45,915.03	(6,249.85)
Үндсэн хөрөнгө	436,747.69	415,837.87	(20,909.82)
Нийт хөрөнгө	488,917.57	470,940.81	(17,976.76)
Өр төлбөр	-	4,819.82	4,819.82
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	488,918.57	466,122.00	(22,796.57)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	488,918.57	470,941.81	(17,976.76)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Тус байгууллага 13,399.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж дахин ашиглах боломжтой 4,920.4 мянган төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг тогтоон бүртгэлд тусгасан, тайланд хугацаанд 25,827.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 519,965.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс 31,717.3 мянган төгрөгөөр бууруулж 488,247.7 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт Булган сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 07-ны XI хуралдааны 19 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийг 105,406.3 мянган төгрөгөөр, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны А/793 тоот захирамжаар 597.9 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 382,243.5 мянган төгрөгийн, орон нутгаас 106,004.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 479,059.8 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 9,187.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	84,240.60	84,240.60	0.00	100%
2	80112	Нийтлэг үйлчилгээ	21,763.60	21,763.60	0.00	100%
3	81605	Эрүүл мэндийг дэмжих	1,100.00	1,100.00	0.00	100%
4	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	38,490.00	38,490.00	0.00	100%
5	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,240.50	1,240.50	0.00	100%
6	81823	Боловсролын байгууллагын багш,	1,100.00	1,100.00	0.00	100%
7	81834	Боловсролын стандарт, сургалт	287,160.80	287,160.80	0.00	100%
8	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	53,152.20	53,152.20	0.00	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлтээр санхүүжилт ороогүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 488,247.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,323.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 21,806.6 мянган төгрөгийн 2 удаагийн шийдвэр болон тендерийн мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Хувийн авто машин хэрэглэн 150.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Хэмнэлтийн тухай хуулийн 6.3-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, зайлшгүй хувийн автомашин ашиглах тохиолдолд гэрээ байгуулж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр 24 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	95.2	1	95.2	100
Албан шаардлага	2	420.0	2	420.0	100
Зөвлөмж					
Нийт дүн	3	515.2	3	515.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй газрын гэрчилгээгүй 2,163.2 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн талбайг анхаарах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

Аудитаар нийт 7,003.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 4,920.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 2,082.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

5.2 Албан шаардлага

Захирлын 2022 оны 12 дугаар сарын 07-ны Б/34 тоот тушаалаар комисс томилогдон тооллогыг 08-18-ны өдөр хийсэн ч тооллогыг үнэн зөв хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 72, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийг зөрчсөн, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхдэд олгох зардлын нормоос 1-3,5 сард илүү, 4, 9-12 сард дутуу тооцон зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолын 2-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхдэд олгох зардлын нормоор тооцон олгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	-	0	-	0	-	0	-	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхдэд олгох зардлын нормоор олгоогүй	1	2,082.90					1	2,082.90				
Үндсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хөтлөөгүй	1	4,920.40			1	4,920.40						
Дүн	2	7,003.30	0	0	1	4,920.40	1	2,082.90	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд шийдвэр болон тендерийн мэдээллийг байршуулаагүй	1	56,782.70			1	56,782.70		
Дүн	1	56,782.70	0	0	1	56,782.70	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Албан хэрэгцээнд хувийн авто машин ашигласан	1	150.00			1	150.00		
Дүн	1	150.00	0	0	1	150.00	0	0
Нийт дүн	2	56,932.70	0	0	2	56,932.70	0	0

-oOo-